

НИЙСЛЭЛ, НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД ХЭРЭГЖСЭН  
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжсэн Нийтийн зориулалттай орон сууцны барилгын 4 цахилгаан шатны шинэчлэлтийн ажил 100 хувь бүрэн хэрэгжиж, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан.

Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд шинэчлэгдэж байгаа нийт нийтийн зориулалттай орон сууцны барилгын 59 цахилгаан шатны шинэчлэлийн ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1504 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх Багц-1 ажил (СХД)-ыг “Оакс экспресс Монголиа” ХХК гүйцэтгэсэн. Тус гэрээт ажлаар Баянгол дүүргийн Нийтийн зориулалттай орон сууцны 10 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг бүрэн гүйцэтгэж, 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.
2. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1504 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх Багц-2 ажил (БЗД)-ыг “Оакс экспресс Монголиа” ХХК гүйцэтгэсэн. Тус гэрээт ажлаар Баянзүрх дүүргийн Нийтийн зориулалттай орон сууцны 12 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг бүрэн гүйцэтгэж, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.
3. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1504 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх Багц-3 ажил (СХД)-ыг “Фүшили элеватор” ХХК гүйцэтгэсэн. Тус гэрээт ажлаар Сонгинохайрхан дүүргийн Нийтийн зориулалттай орон сууцны 7 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг бүрэн гүйцэтгэж, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.
4. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1504 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэх Багц-4 ажил (СБД, ЧД, ХУД)-ыг “Фүшили элеватор” ХХК гүйцэтгэсэн. Тус гэрээт ажлаар Сүхбаатар, Чингэлтэй, Хан-уул дүүргийн Нийтийн зориулалттай орон сууцны 6 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг бүрэн гүйцэтгэж, 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.
5. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1528 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэлтийн ажил (7 цахилгаан шат), их засварын ажил (2 цахилгаан шат)-ыг,

“Оакс экспресс Монголиа” ХХК гүйцэтгэсэн. Тус гэрээт ажлаар Баянгол дүүргийн Нийтийн зориулалттай орон сууцны 7 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг гүйцэтгэж, 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан.

6. Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/141 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг “Оакс экспресс Монголиа” ХХК гүйцэтгэсэн. Тус гэрээт ажлаар Баянгол дүүргийн Нийтийн зориулалттай орон сууцны 6 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг гүйцэтгэж, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн.
7. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/725 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэлтийн ажил (Улаанбаатар хот)-ыг “Оакс экспресс монголиа” ХХК 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 угаар сарын 30-ны хооронд гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Тус гэрээт ажлаар 9 цахилгаан шатны шинэчлэлийн ажил хийгдэж бөгөөд гэрээт ажил 60 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.
8. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1157 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны засвар (БЗД, 3 дугаар хороо)-ын ажлыг “Оакс экспресс монголиа” ХХК 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.
9. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын А/155 дугаар тушаалын хүрээнд хэрэгжиж буй Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо, 54-р байр (9-н зогсоолтой 1ш лифт)-ны лифт шинэчлэх ажлыг “Оакс экспресс монголиа” ХХК 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.

ХЯНАСАН:

УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ-ЫН  
ДАРГА



Д.ГАН-ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ-ЫН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕРИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ ХЯНАЛТЫН ИНЖНЕР

A handwritten signature in black ink, likely belonging to the Chief Engineer mentioned in the text below.

Ц.УРАНБИЛЭГ